

@



БАЙГАЛЬ ОРЧИН,
НОГООН ХӨГЖЛИЙН ЯАМ

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЛБАРЫН ЖЕНДЭРИЙН СТРАТЕГИ 2014-2030



Улаанбаатар хот, 2014

ГАРЧИГ

Товчилсон үгс

Стратегид хэрэглэсэн нэр томъёоны тайлбар

Өмнөх үг

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун

1. ЖЕНДЭРИЙН СТРАТЕГИЙН ҮНДЭСЛЭЛ БА ХҮРЭЭ

- 1.1. Байгаль орчны салбарын жендэрийн нөхцөл байдал
- 1.2. Жендэрийн стратегийн зорилтот бүлгүүд
- 1.3. Жендэрийн стратегийн хандлага, хамрах хүрээ

2. ЖЕНДЭРИЙН СТРАТЕГИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО, СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 2.1. Эрхэм зорилго
- 2.2. Стратегийн зорилго
- 2.3. Стратегийн зорилт, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

3. ЖЕНДЭРИЙН СТРАТЕГИЙН ХЭРЭГЖИЛТ

- 3.1 Стратегийг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалт
- 3.2 Стратегийн санхүүжилт
- 3.3 Стратегийн хэрэгжилтийн хяналт үнэлгээ, тайлагналт
- 3.4. Хамтын ажиллагаа

Хавсралт 1. Стратегийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлүүд, хэрэгжилтийн үе шатаар

Хавсралт 2. Стратегийн зорилгуудын хүрэх үр дүн ба үндсэн шалгуур үзүүлэлтүүд, хэрэгжилтийн үе шатаар

Товчилсон үгс

БОНХЯ	Байгаль орчин, ногоон нөгжлийн яам
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
НҮБХХ	Нэгдсэн үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөр
ЖҮХ	Жендэрийн үндэсний хороо
ҮСХ	Үндэсний статистикийн хороо

Стратегид хэрэглэсэн нэр томъёоны тайлбар

- 1. Жендэрийн мэдрэмж** гэж эмэгтэй эрэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүдийн ялгаатай хэрэгцээг, мөн тэдний хөгжлийн үйл явцад оролцох болон үр шимийг нь хүртэхэд хязгаарлалт болж буй хүчин зүйлсийг анхаарч тооцох хүсэл эрмэлзэл, мэдлэг, чадвар юм.
- 2. Жендэрийн тэгш байдал** гэдэг нь эмэгтэй эрэгтэй хүмүүс нийгэмдээ болон хувийн амьдралын хүрээндээ эн тэгш үнэлэгдэж, тэгш эрх мэдэл, оролцоотой байж, хөгжлийн үйл явцад оролцох болон үр шимийг нь хүртэх тэгш боломжоор хангагдахыг хэлнэ.
- 3. Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах (Gender mainstreaming)** гэдэг нь бүх хүрээ, бүх түвшний аливаа бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны, түүний дотор хууль тогтоомж, төсөл хөтөлбөрийн эмэгтэй эрэгтэй хүмүүст, нийгмийн бүлгүүдэд ялгаатай нөлөөлөх байдлыг анхаарч тооцох, тэдний ялгаатай хэрэгцээ болон мэдлэг туршлагыг эн тэнцүү үнэлж, анхаарах үйл явц, стратеги юм.
- 4. Жендэрийн статистик** гэдэг нь хүйсээр ангилсан тоон мэдээлэл болон тухайн цаг үеийн нийгмийн хэрэгцээнд тохирсон арга хэрэгслийн тусламжтайгаар жендэрийн хэвшмэл сэтгэлгээг, улмаар тэгш шударга бус нөхцөл байдлыг өөрчлөхөд чиглэсэн бодлого боловсруулах үйл явц юм.
- 5. Жендэрийн дүн шинжилгээ** гэж бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа нийгмийн янз бүрийн бүлгийн эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хэрэгцээнд суурилсан эсэхийг, оролцох болон үр ашиг хүртэх тэгш боломжийг тэдэнд бий болгож байгаа эсэхийг үнэлэн судалж, анхаарч тооцох үйл явц юм.
- 6. Жендэрийн хяналтын хуудас** гэдэг нь аливаа бодлого хөтөлбөр, үйл ажиллагааны үе шат бүрт жендэрийн нөхцөл шалгах асуултын жагсаалт, эсхүл жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд нэгтгэх ажлыг хариуцан хийж байгаа хүмүүсийн тухайн ажлын хүрээнд хүлээсэн үүрэг даалгавраа бүрэн гүйцэтгэж байгаа эсэхээ хянахад ашиглах жагсаалт юм.
- 7. Жендэрийн үр нөлөөний үнэлгээ** гэж бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа нийгмийн янз бүрийн бүлгийн эрэгтэй эмэгтэй хүмүүст хэрхэн ялгаатай нөлөөлж байгааг судлан шинжилж, сөрөг нөлөөг нь арилгах арга замыг тодорхойлох хэрэгсэл юм. Энэ нь олон талын, түүний дотор бодлого төлөвлөлт, үйл ажиллагааны нөлөөнд өртөж буй хүмүүсийн оролцоотой хийгдэнэ.

ӨМНӨХ ҮГ

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун

НЭГ. ЖЕНДЭРИЙН СТРАТЕГИЙН ҮНДЭСЛЭЛ БА ХҮРЭЭ

Монгол улсын байгаль орчны салбарын жендэрийн стратеги нь үндэсний болон олон улсын түвшинд зөвшөөрөгдөн батлагдсан дараах эрх зүй, бодлогын хүрээ болон баримтын судалгаанд үндэслэсэн болно. Үүнд:

Рио де Жанейрод хуралдсан дээд хэмжээний уулзалтын (*Rio+20*) “Бидний хүсч буй ирээдүй” баримт бичигт тогтвортой хөгжлийг дэмжих ажилд улс орнуудын гүйцэтгэх үүрэг хариуцлагыг шинэчлэн баталж, улмаар жендэрийн тэгш оролцоог урамшуулан дэмжихийг уриалжээ. Энэ баримт бичигт байгалийн нөөцийн доройтол ба цөлжилттэй тэмцэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үйл ажиллагаанд жендэрийн тэгш оролцоог ханган, эмэгтэйчүүдийг [ногоон] эдийн засагт бүрэн оролцуулан, нөөцийг зохистой хуваарилах замаар тогтвортой хөгжлийн үндэсний чадавхийг дээшлүүлэх шаардлагатайг заажээ.

Биологийн олон янз байдлын тухай конвенци (*CBD*)-д жендэрийн тэгш байдлыг хөхүүлэн дэмжиж, конвенцийн зорилтуудыг хэрэгжүүлэхдээ Айчи-гийн зорилтууд, “Биологийн төрөл зүйлийг хамгаалах, хөгжүүлэх стратеги, үйл ажиллагааны хөтөлбөрт (2011-2020) жендэрийн асуудлыг тодорхой тусгах чиглэл өгөгджээ.

Цөлжилттэй тэмцэх НҮБ-ын конвенци (*UNCCD*)-д хөдөөгийн эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүргийг хүлээн зөвшөөрч, тэдний ахуй амьдралыг дээшлүүлэн байгалийн нөөцийн ашиглалт хамгаалалтыг сайжруулан, эко-системийн үйлчилгээг дэмжиж, тэгш оролцоог ханган улмаар технологи дамжуулах ур чадвар, чадавхийг дээшлүүлэх шаардлагатай гэжээ.

Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх НҮБ-ын конвенци (*UN FCCC*)-д жендэрийн тэгш байдалд чиглэсэн системтэй сургалт зохион байгуулж, түншлэлийг хөхүүлэн дэмжихийг уриалжээ.

Бээжингийн дэлхийн эмэгтэйчүүдийн IV бага хурлаас дэвшүүлэн баталсан үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр (*Beijing+20*)-т тэргүүлэх 12 асуудлын хүрээг тодорхойлсоны нэг нь “К- Эмэгтэйчүүд ба хүрээлэн буй байгаль орчин”-ы асуудал билээ. Тус баримт бичигт төр засаг, нутгийн захиргаад, төрийн бус байгууллагууд болон хувийн хэвшлийнхэнд зориулсан стратеги, арга хэмжээг санал болгон эко-системийн хамгаалалт болон тогтвортой хөгжлийн стратеги, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэхэд эрэгтэй эмэгтэй хүмүүсийг тэгш оролцуулан, мониторингийн зохистой механизмыг бүрдүүлж, байгаль орчны салбарын бодлогын жендэрийн нөлөөллийг үе шаттай үнэлэх тогтолцоог буй болгох шаардлагатай гэж заасан байдаг.

УИХ-аар батлагдсан “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д “... амьтан, ургамлыг хамгаалах, тарималжуулах, нөхөн сэргээх, хяналт-шинжилгээ хийх ажилд иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшил, нутгийн иргэдийг түлхүү татан оролцуулах зарчим баримтална” гэж заажээ.

Монгол улсын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх Засгийн газрын дунд хугацааны стратеги (2012-2016), мөн БОНХЯ-аас шинээр боловсруулж буй Ногоон хөгжлийн бодлого нь дээрх олон улсын болон үндэсний баримт бичгүүдийн заалтыг Монгол улсад хэрэгжүүлэх үндэсний эрх зүйн орчин, бодлогын үндэс болж байна.

Байгаль орчны салбарын жендэрийн стратеги боловсруулах баг нь Германы хамтын ажиллагааны дэмжлэгтэйгээр 2014 оны 3-5 дугаар саруудад Монгол улсын байгаль орчны салбарын жендэрийн нөхцөл байдлыг тодруулах зорилгоор баримтын судалгаа хийж, тодорхой асуудлуудын хүрээнд (уур амьсгалын өөрчлөлт цөлжилт, ой, ус) сэдэвчилсэн хэлэлцүүлгүүд зохион байгуулж, салбарын бодлого боловсруулагчид, иргэний нийгмийн байгууллагуудын саналыг авсан билээ. Эдгээр ажил нь жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг салбарын бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах боломж, саад бэрхшээлийг тодорхойлох, орон нутагт болон салбарын үйл ажиллагааны тодорхой чиглэлүүдэд жендэрийн стратегийг нийцүүлэн хэрэгжүүлэх арга замыг илрүүлэх үндэс болсон.

1.1. Байгаль орчны салбарын жендэрийн нөхцөл байдал

Монгол орны уур амьсгал, байгалийн нөөц баялаг нь эрт үеэс өнөөг хүртэл оршин сууж ирсэн монголчуудын зан заншил, аж амьдралын хэв маяг, аж ахуй эрхлэлт, түүний дотор эмэгтэй эрэгтэй хүмүүсийн хөдөлмөрийн хуваарь, гэр бүл, нийгэмдээ гүйцэтгэх үүргийг тодорхойлж, ингэснээрээ монгол үндэстний жендэрийн харилцааг төлөвшүүлэх суурь нөхцөл болж ирсэн билээ. Уур амьсгал, байгалийн нөөцөд гарч буй сөрөг өөрчлөлт, ялангуяа цөлжилт, байгалийн нөөцийн хорогдол нь хот хөдөөгийн бүх насны эмэгтэй эрэгтэй хүмүүст, нийгмийн бүлгүүдэд харилцан адилгүй нөлөөлж, улмаар нийгэм дэх тэгш бус байдлыг улам гүнзгийрүүлж улмаар ядуурал, эрүүл мэндийн эрсдэл, шилжих хөдөлгөөн зэрэг нийгмийн олон тулгамдсан асуудлыг хурцатгах хүчин зүйл болж байна.

Сүүлийн жилүүдэд улам тулгамдаж буй уул уурхайн нөлөө, хот суурин газрын агаарын бохирдол, хатуу болон аюултай хог хаягдал болон бохир усны менежменттэй холбоотой асуудлууд нь байгаль орчинд сөргөөр нөлөөлөхийн зэрэгцээ хүн амын эрүүл мэнд аюулгүй байдлын эрсдэлийг ихэсгэж, амьдралын чанарыг муутгаж байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн гэрч: Наранхүүгийн Маруш



Н.Марушийн ярианаас:

Миний нэр Наранхүүгийн Маруш. Энэ жил нас сүүдэр 67 хүрч байна. Миний уугуул болоод суугуул нутаг Ховд аймгийн Чандмань сумын Цагаан гол хэмээх энэ газар. Хэзээнээс нааш манай өвөг дээдэс энэ нутагт мал аж ахуй эрхлэн аж төрж ирсэн. Би эхээс төрсөн цагаасаа энэ нутагтаа малчин явсан. Сургууль соёлд яваагүй. Би 14 хүүхэд төрүүлсэн. Дөрвөн хүүхэд маань малчин болсон, бусад нь хот суурин газар бий.

Намайг залуу байхад манай нутаг их сайхан байсан. Ногоо цагаа элбэг дэлбэг, зуншлага сайхан, өвөл, хавар, намар ч дэлгэр байдаг байлаа. Хар-Ус нуур сүүлийн дөрөв, таван жилийн дотор л огцом ширгэж байна. Гар худагнууд ч ширгэж байна. Энэ Хар-Ус нуурын үүгээр жаахан жаахан цойрмог цөөрмүүд байсан юм. Тэр бүгд байхгүй. Энэ гэр барьчихсан байгаа газар чинь нэл ус байсан газар.

Ойрын дөрөв, таван жил их хүндрэлтэй байна. Энэ байгалийн нөхцөлд мал туранги. Ногоо гарахгүй болохоор бид чинь яг л энэ байгальдаа захирагдах юм даа. Энэ хэдэн мал зөвхөн голынхоо хөвөөгөөр ногоо хазаж байгаа болохоор даацаа дийлэхээ болихоос ч аргагүй. Энд бэлчээр байлаа гэхэд мал услах нөхцөл байхгүй. Ойр орчимд булаг шанд байдаггүй. Нуурын ус татаад шавар болчихсон. Малтай улсууд нуур луугаа шахаж нуурын арал дээр бууж байгаа нь усны эрхшээлд л орсон хэрэг шүү дээ.

Би ч нас дээр гарлаа. Харин энэ ард түмэн, үр хүүхэд минь хэдэн малтайгаа байх юм уу, байхгүй юм уу гэдэг дээрээ тулчихаад байхад төр засгаас их л зөв арга хэмжээ авах хэрэгтэй байна даа. Ус чийгийг яаж нэмэгдүүлдэг юм, яаж энэ хуурайшилтыг зогсоодог юм бүү мэд. Харин хоорондоо эе эвээ ололцож энэ хүнд байдлаас гарахад манай гадна дотны төсөл хөтөлбөрийн олон ажил хийгдэж байдаг юм. Жишээ нь манай Цагаан голд "Жаргалант оргил" гэдэг байгаль хамгаалах нөхөрлөл бий. Тэд малынхаа тооны араас хөөх биш харин малынхаа үс ноосоор сайхан бүтээлүүд хийж байгаа.

ДБХС (WWF) Уур амьсгалын гэрч

ба

Нөгөө талаас сүүлийн жилүүдэд эрчтэй өрнөж буй нийгэм соёлын шилжилт нь монголын хот хөдөөгийн эмэгтэй эрэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүдийн үнэт зүйл, түүний дотор байгаль орчноо хамгаалах уламжлалт соёл, байгалийн нөөц баялагт хандах байдалд сөргөөр нөлөөлж байгаа бөгөөд энэ бүхэн нь эргээд байгаль орчинд ихээхэн дарамт учруулж, байгаль орчны бодлого төлөвлөлт, үйл ажиллагааны дүнг бууруулах хүчин зүйл болж байна. Иймээс дээрх тулгамдсан асуудлыг шийдэх арга замыг байгаль орчин, жендэр ба тогтвортой хөгжлийн харилцан уялдааны хүрээнд эрж хайх хэрэгцээг бий болжээ.

2013 оны байдлаар улсын хэмжээнд 35 ойн ангид дарга, инженер техникчид, үйлчилгээний ажилтан, улирлын ажилчин нийт 191 хүн ажиллаж байгаагаас нийт ажиллагсадын 44% нь эмэгтэйчүүд, 46% нь эрэгтэйчүүд байна. Ойн ангиудын нийт хүний нөөцийн 39% нь улирлын ажилчид байна.

Монгол улсын ойн салбарын
хүний нөөц. 2013

ҮР

БОНХЯ нь салбарын жендэрийн стратеги боловсруулан хэрэглэх санаачлагыг Засгийн газрын байгууллагуудаас анхлан гаргасан бөгөөд жендэрийн салбар зөвлөлийг байгуулан, жендэрийн мэргэжилтнийг томилон ажиллуулж байна. Байгаль орчны салбарын үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж буй эрх зүйн болон бодлогын гол бичиг баримтуудад, тухайлбал ойн тухай хуулинд нөхөрлөл, иргэдийн эрх үүргийг тусгасан, усны тухай хуулинд усны нөөцөд түшиглэсэн менежментийн заалтууд орсон, усны аюулгүй байдал, сав газрын менежмент болон иргэдийн оролцоотой менежментийн чиглэлээр сүүлийн жилүүдэд түлхүү ажиллаж байгаа зэрэг нь жендэрийн стратегийг нэгтгэн хэрэгжүүлэх бодлого, эрх зүйн таатай орчныг бүрдүүлж байна.

Ногоон хөгжлийн бодлого салбарын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл болсноор байгаль орчны бодлого хөтөлбөр, үйл ажиллагааг нийгэм эдийн засгийн зорилготой уялдуулан цогц байдлаар хэрэгжүүлэх өргөн боломж нээгдэж байгаа нь БОНХЯ-нд жендэрийн стратегийг боловсруулан хэрэгжүүлэх, салбарын бусад байгууллага, ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх бусад салбаруудад туршлагаа түгээн дэлгэрүүлэх тохиромжтой цаг үе юм.

Байгаль орчны салбарын жендэрийн стратеги нь хүн амын бүлгүүдийн хөгжлийн харилцан адилгүй хэрэгцээг бодлого төлөвлөлтөд тусгах замаар байгаль орчны бодлого, хөтөлбөр, төлөвлөсөн үйл ажиллагаанд тэгш оролцох болон байгалийн нөөц баялгийг ашигласны үр өгөөжийг тэгш шударгаар хүртэх боломжийг нь дэмжихэд чиглэх бөгөөд дараах зүйлсэд онцлон анхаарна. Үүнд:

- Байгаль орчны өнөөгийн тогтолцооны чадавхийг сайжруулах, хүний нөөцийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулан салбарын хууль тогтоомж, бодлого хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг улам үр өгөөжтэй, хүртээмжтэй болгох,
- Байгаль орчны салбарын ажиллагсад болон нийт хүн амын хөдөлмөр эрхлэлт дэх жендэрийн ялгааг багасгаж, хөдөөгийн болон хотын гэр хорооллын оршин суугчдын эрүүл аюулгүй амьдрах нөхцлийг дээшлүүлэн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай Монгол улсын хуулийн хэрэгжилтэд хувь нэмэр оруулах,
- Нийгэм эдийн засаг, дэд бүтцийн бусад салбарын жендэрийн стратегид жишиг болж байгаль орчин, ногоон хөгжлийн асуудлаарх салбар хоорондын үйл ажиллагааны жендэрийн уялдааг сайжруулах.

1.2. Жендэрийн стратегийн зорилтот бүлгүүд

Жендэрийн стратегийн үр шимийг хүртэгчдийг уг стратегийн хэрэгжилттэй холбоотой хүлээх үүрэг хариуцлага, гүйцэтгэх үйл ажиллагааны чиглэлийн хувьд, мөн стратегийн хэрэгжилтэд оролцох цаг хугацааны хувьд ялгаатай дараах 4 бүлэгт хуваан авч үзнэ. Үүнд:

- 1. Байгаль орчны салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж хэрэгжилтийг удирдагчид.** Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, мөн УИХ-ын байгаль орчны асуудал хариуцсан байнгын хороо болон байгаль орчин, ногоон хөгжлийн асуудлаар ажиллаж буй бусад үндэсний зөвлөл, хороод, хэрэгжүүлэгч агентлагуудын шийдвэр гаргагчид энэ бүлэгт орно. Энэ бүлэг нь жендэрийн стратегийг хамтран боловсруулж батлуулах, жендэрийн мэдлэг, жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлтөд тусгах арга зүйг эзэмшин стратегийн хэрэгжилтийг удирдан зохицуулах үүрэгтэй.
- 2. Байгаль орчны салбарын бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг гардан хэрэгжүүлэгчид.** Аймаг, сум, нийслэл, дүүрэгт салбарын бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг гардан хэрэгжүүлж буй шийдвэр гаргагчид, мэргэжилтнүүд, хөтөлбөр төслийн ажилтнууд энэ бүлэгт орох бөгөөд жендэрийн стратегийг гардан хэрэгжүүлэх, сайжруулах, түгээн дэлгэрүүлэх үүргийг гүйцэтгэнэ. Энэ бүлэг нь жендэрийн стратегийг хэрэгжүүлэхэд шаардагдах мэдлэг, арга зүйг эзэмшихээс гадна жендэрийн ялгаатай хэрэгцээг судлаж, салбарын бодлого төлөвлөлтдөө тусгах үүрэгтэй оролцоно.
- 3. Байгаль орчны салбарын бодлого, хөтөлбөр, төлөвлөсөн үйл ажиллагаанд шууд оролцож буй хүн амын хэсэг, бүлгүүд.** Үндэсний болон орон нутгийн түвшинд байгаль орчны чиглэлээр ажиллаж буй ТББ-ууд, эвсэл холбоод, сав газрын зөвлөл, ойн нөхөрлөлд ажиллаж буй хүмүүс энэ бүлэгт орно. Энэ бүлэг нь салбарын жендэрийн стратегийг хэрэгжүүлэх гол оролцогчид юм. Эдгээр гол оролцогчид нь салбарын жендэрийн стратегийг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлэхэд, хүн амын бүлгүүдийн хэрэгцээг судлах буюу илэрхийлэх, бодлого төлөвлөлтийг тэдний жендэрийн хэрэгцээнд чиглүүлэхэд ялангуяа орон нутгийн түвшинд гол үүрэгтэй. Гэхдээ тэдний оролцоог хангахын тулд жендэрийн стратегийн хэрэгжилтэд үр бүтээлтэй оролцох боломжийг нь нээсэн зохицуулалт, мэдлэг мэдээлэл, удирдлага санхүүжилтийн системтэй дэмжлэг шаардлагатай болно.
- 4. Байгаль орчны салбарын бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний үр шимийг хүртэгч нийт хүн ам.** Монгол улсад амьдарч буй хот хөдөөгийн нийт хүн ам энэ бүлэгт хамрагдана. Байгаль орчны бодлого төлөвлөлт, хэрэгжилтийн хүн амд нөлөөлөх байдлыг үе шаттай үнэлж, хэрэгцээг нь салбарын бодлого болон хөгжлийн бусад хөтөлбөрт тусгаж байх нь байгаль орчны салбарын бодлого төлөвлөлтөд бүх насны эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хувь нэмэр оруулах, хэрэгжилтийг хянах бодит боломжийг нээж өгнө.

1.3. Жендэрийн стратегийн хандлага, хамрах хүрээ

Байгаль орчны салбарын жендэрийн стратеги нь салбарын бодлого төлөвлөлт, үйл ажиллагааг илүү үр өгөөжтэй, оновчтой, нээлттэй болгон ногоон хөгжлийг дэмжихийг зорихдоо эмэгтэй эрэгтэй хүмүүсийн, нийгмийн бүлгүүдийн жендэрийн хэрэгцээг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд эн тэнцүү харгалзан үзэх, тэднийг хөгжлийн хөдөлгөгч хүч гэж үзэх “Жендэр ба Хөгжил” хандлагыг баримтлах бөгөөд энэ нь дараах хоёр зарчмаар хэрэгжинэ. Үүнд:

- Байгаль орчны салбарын бодлого төлөвлөлт, үйл ажиллагааны үр нөлөө эмэгтэй эрэгтэй хүмүүс, охид хөвгүүд, нийгмийн бүлгүүдэд харилцан адилгүй тусч байгааг, тэдний ногоон хөгжилд оролцох боломж, чадавхи ялгаатай байгааг анхаарч судлах, бодлого төлөвлөлтөд тусгах жендэрийн мэдрэмжтэй байх зарчим.
- Байгаль орчны салбарт ажиллаж байгаа болон салбарын бодлого төлөвлөлт, үйл ажиллагааны үр шимийг хүртэж байгаа хот хөдөөгийн эмэгтэй эрэгтэй хүмүүс, охид хөвгүүд, нийгмийн бүлгүүдийг чадавхижуулах замаар ногоон хөгжилд илүү өргөн хүрээнд үр өгөөжтэй оролцон үр шимийг нь хүртэх боломжийг нь нэмэгдүүлэх, улмаар нийгэм дэх жендэрийн тэгш бус байдлыг арилгахад бодитой хувь нэмэр оруулах жендэрийн хувьд өөрчлөн сайжруулах зарчим.

Жендэрийн стратеги нь байгаль орчны салбарын үйл ажиллагааны бүх чиглэлд орон нутгийн онцлог хэрэгцээ, хүн амын бүлгүүдийн, эмэгтэй эрэгтэй хүмүүсийн оролцооны харилцан адилгүй цар хүрээ, түвшинд тохируулан ашиглаж болох удирдамж юм. Тиймээс энэ стратегид төлөвлөсөн үйл ажиллагааны чиглэлүүдийг үндэсний болон орон нутгийн түвшинд ажиллаж буй салбарын байгууллагууд болон түншлэгчдэд өөрсдийн нөхцөл байдал, хэрэгцээнд хамгийн нийцтэй, ашиг тустай байдлаар тохируулан хэрэгжүүлэх, сайжруулан өөрчлөх боломжтой.

Мөн байгаль орчны чиглэлийн үйл ажиллагаа нь үндэсний болон орон нутгийн түвшинд хөдөө аж ахуй, эдийн засаг, уул уурхай, барилга хот байгуулалт, боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгэм эдийн засаг, дэд бүтцийн бусад салбаруудын үйл ажиллагаатай ихээхэн уялдаатай учир энэ стратегийн хүрээнд хамтын ажиллагааг хөгжүүлэх шаардлагатай. Тухайлбал стратегийн хүрээнд жендэрийн тэгш байдлын талаар нэгдсэн ойлголт бий болгох, жендэрийн дүн шинжилгээний чадавхи бүрдүүлэх үйл ажиллагаанд дээрх салбаруудын түншлэгчдийг хамруулах, жендэрийн судалгаа шинжилгээг хамтран хийх боломж нээлттэй.

ХОЁР. ЖЕНДЭРИЙН СТРАТЕГИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО, СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. Эрхэм зорилго, стратегийн зорилго, зорилт

Байгаль орчны салбарын жендэрийн стратегийн эрхэм зорилго нь эмэгтэй эрэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүд, орон нутгийн хөгжлийн хэрэгцээнд суурилсан, оролцоог болон үр өгөөжийг тэгш хүртэх боломжийг хангасан ногоон хөгжлийг дэмжихэд оршино.

Энэхүү эрхэм зорилгод хүрэхийн тулд салбарын үйл ажиллагааны бүх хүрээ, түвшинд дараах стратегийн зорилго, зорилтуудыг 2030 он гэхэд бүрэн хэрэгжүүлэхийн төлөө чармайна. Үүнд:

Стратегийн зорилго 1. Байгаль орчны салбарын жендэрийн дүн шинжилгээ, төлөвлөлт хийх чадавхийг бүрдүүлэх.

Зорилт 1.1. Байгаль орчны салбарын бодлогод жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг тусгах талаар нэгдсэн ойлголттой болох.

Зорилт 1.2. Байгаль орчны салбарын жендэрийн дүн шинжилгээ, жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлтийг хөгжүүлэх.

Тайлбар: Аливаа бодлого хөтөлбөр, үйл ажиллагааг эмэгтэй эрэгтэй хүмүүсийн, нийгмийн бүлгүүдийн хөгжлийн хэрэгцээг тусгах замаар илүү оновчтой, үр өгөөжтэй болгох, нийгэм дэх тэгш бус байдлыг арилган амьдралын чанарыг дээшлүүлэхийн тулд жендэрийн дүн шинжилгээг тогтмол хийх шаардлагатай. Хүйсээр ангилсан статистик мэдээлэл, хяналтын хуудас, жендэрийн шалгуур үзүүлэлтүүд, жендэрийн мэдрэмжтэй судалгааг хөгжүүлэн бодлого төлөвлөлтөд ашиглаж хэвшихийн тулд үүнд оролцогч бүх талууд нэгдсэн ойлголттой болох, нэгдсэн арга зүй ашиглахыг шаардана. Стратегийн 1-р зорилго нь зорилтуудынхаа хамтаар байгаль орчны салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж хэрэгжилтийг удирдагчид (Бүлэг 1.), бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг гардан хэрэгжүүлэгчид (Бүлэг 2.) болон шууд оролцож буй хүн амын хэсэг, бүлгүүдэд (Бүлэг 3.) чиглэгдэнэ.

Стратегийн зорилго 2. Байгаль орчны салбарын менежментийг жендэрийн мэдрэмжтэй болгох.

Зорилт 2.1. Байгаль орчны салбарын эрх зүйн орчин, бодлого төлөвлөлтийг жендэрийн мэдрэмжтэй болгох.

Зорилт 2.2. Байгаль орчны салбарын бодлого төлөвлөлтөд бүх шатны хэрэгжүү-лэгчдийн, түүний дотор эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх.

Зорилт 2.3. Байгаль орчны бодлого төлөвлөлт болон орон нутгийн хөгжлийн бодлогын жендэрийн уялдааг сайжруулах.

Тайлбар: Байгаль орчны салбарын бодлого, хөтөлбөр, төлөвлөлт, мөн тэдгээрийн хэрэгжилтийн бүх шатанд тухайн салбарт ажиллаж байгаа болон үр шимийг хүртэгч эмэгтэй эрэгтэй хүмүүс чанартай, үр өгөөжтэй оролцох боломжийг бүрдүүлэх шаардлагатай. Үүний тулд салбарын байгууллагууд нь жендэрийн хувьд тэгш оролцоог хангасан, мэдээллийн нээлттэй эргэх холбоо бүхий дотоод орчин, соёлыг бүрдүүлэх хэрэгтэй. Байгаль орчны салбарын бодлого төлөвлөлтийг эмэгтэй эрэгтэй хүмүүст, нийгмийн бүлгүүдэд бодитоор нийцүүлэн амьдралд нь өөрчлөлт гаргах, мөн салбарын үйл ажиллагааны үр өгөөжийг дээшлүүлэхийн тулд орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан цогц хэлбэрээр хэрэгжүүлэх шаардлагатай болно. Стратегийн 2-р зорилго нь зорилтуудынхаа хамтаар байгаль орчны салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж хэрэгжилтийг удирдагчид (Бүлэг 1.), бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг гардан хэрэгжүүлэгчдэд (Бүлэг 2.) чиглэгдэнэ.

Стратегийн зорилго 3. Эмэгтэй эрэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүд, орон нутгуудад ногоон хөгжилд оролцох, үр ашгийг нь хүртэх илүү өргөн боломжийг нээх.

Зорилт 3.1. Байгаль орчны салбарын мэдээллийг илүү хүртээмжтэй болгох, эмэгтэй эрэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүд, орон нутгуудын оролцооны чадавхийг дээшлүүлэх

Зорилт 3.2. Орон нутгийн иргэд, бүлэг нөхөрлөлүүд, эрдэм шинжилгээний байгууллагууд, ТББ болон олон улсын байгууллагуудыг байгаль орчны салбарын бодлого төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээнд илүү үр дүнтэй оролцуулах

Зорилт 3.3. Эмэгтэй эрэгтэй хүмүүсийн, нийгмийн бүлгүүдийн, орон нутгуудын хэрэгцээнд нийцсэн ногоон ажлын байрыг нэмэгдүүлэх

Тайлбар: Хот хөдөөгийн оршин суугчид, тэдний бүлэг, байгууллагуудыг ногоон хөгжлийн хөдөлгөгч хүч хэмээн үзэж байгаль орчны салбарын үйл ажиллагаанд илүү утга учиртай, үр өгөөжтэй, оролцох боломжийг нээх шаардлагатай. Үүний тулд юуны өмнө мэдээлэл түгээх, чадавхижуулах, хамтын ажиллагааг хөгжүүлэхдээ орон нутаг, хүн амын бүлгүүдийн хэрэгцээ, боломжийг харгалзан үзэх хэрэгтэй. Ингэснээр ногоон хөгжилд хувь нэмэр оруулахын зэрэгцээ жендэрийн ялгаатай байдал багасч, нийгмийн тулгамдсан асуудлууд шийдэгдэж байх гарцыг нээх боломжтой. Жишээ нь уул уурхай ашиглаж буй нутгуудын эмэгтэйчүүдийг уул уурхайн нөхөн сэргээлт, газар тариалан, эко аялал жуулчлал зэрэг ажил эрхлэхийг дэмжих хэрэгтэй. Стратегийн 3-р зорилго нь зорилтуудынхаа хамтаар байгаль орчны салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтэд шууд оролцож буй хүн амын хэсэг, бүлгүүд (Бүлэг 3.) болон үр шимийг нь хүртэгч нийт хүн амд (Бүлэг 4.) чиглэгдэнэ.

Дээрх стратегийн зорилгуудыг хэрэгжүүлэхдээ байгаль орчны салбарын үйл ажиллагааг орон нутгийн хөгжлийн хэрэгцээтэй уялдуулан эхний ээлжинд ногоон хөгжлийн бодлогыг дэмжин загвар болохоор зарласан Архангай, Булган, Өвөрхангай, Ховд, Хэнтий аймаг, нийслэл хотын Сүхбаатар, Сонгинохайрхан дүүрэгт туршиж, улам сайжруулан түгээн боломжтой.

Байгаль орчны салбарын байгууллагууд нь жендэрийн чиглэлээр ажиллах туршлага, нөөц боломж хязгаарлагдмал учраас жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр ажиллаж байгаа үндэсний болон олон улсын байгууллагууд, эрдэмтэн судлаачид, иргэдийн хөдөлгөөн, санаачлагуудтай хамтран ажиллаж, харилцан суралцана.

Стратегийн зорилгуудыг хэрэгжүүлэхэд салбар хоорондын зохицуулалт чухал учраас хөдөө аж ахуй, уул уурхай, барилга, хот тохижилт, эрүүл мэнд боловсрол зэрэг бусад салбарын байгууллагуудтай өргөн хүрээнд түншлэн, хамтран ажиллах шаардлагатай болно.

2.3. Стратегийн зорилт, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Стратегийн зорилго 1. Байгаль орчны салбарын жендэрийн дүн шинжилгээ, төлөвлөлт хийх чадавхийг бүрдүүлэх

Энэ зорилго нь салбарын үйл ажиллагааны үр өгөөжийг дээшлүүлэхэд чиглэх бөгөөд жендэрийн стратеги хэрэгжих суурь нөхцөл болно.

Зорилт 1.1. Байгаль орчны салбарын бодлогод жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг тусгах талаар нэгдсэн ойлголттой болох

Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл:

- Байгаль орчны салбарын ажилтнуудад зориулсан жендэрийн сургалтын хөтөлбөр боловсруулж ашиглах;
- Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг байгаль орчны бодлого хөтөлбөрт тусгах гарын авлага боловсруулах, хэрэглэх;
- Бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны жендэрийн чиг хандлагыг хянах зориулалт бүхий хяналтын хуудас боловсруулан салбарын үйл ажиллагааны бүх чиглэлд ашиглах;
- Байгаль орчны бодлого, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг хэмжих жендэрийн шалгуур үзүүлэлтүүдийг салбарын үйл ажиллагааны чиглэл бүрээр боловсруулж хэрэглэх;
- Жендэрийн судалгаа, дүн шинжилгээ, жендэрийн төсвийн шаталсан сургалт явуулах;
- Ногоон хөгжлийн бодлогыг жендэрийн мэдрэмжтэйгээр хэрэгжүүлэх бусад салбарын болон чиглэлийн яамдын үйл ажиллагаанд хэрэглэх жендэрийн нэгдсэн шалгуур үзүүлэлт гарган турших.

Зорилт 1.2. Байгаль орчны салбарын жендэрийн дүн шинжилгээ, жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлтийг хөгжүүлэх

Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл:

- Байгаль орчны салбарын жендэрийн үнэлгээг стратегийн хэрэгжилтийн үе шат бүрт хийх;
- Жендэрийн статистик мэдээллийг хөгжүүлэх зааварчилгаа гаргаж, мөрдүүлэх;
- Салбарын ажиллагчдын мэргэжлийн болон нийгмийн хөгжлийн хэрэгцээнд жендэрийн судалгаа хийж урт хугацааны хүний нөөцийн хөгжлийн төлөвлөгөө гаргах;
- Салбарын шинээр боловсруулах бодлого хөтөлбөрүүдэд жендэрийн дүн шинжилгээ хийх;
- Байгаль орчны чиглэлээр (ой, ус) оюутан сургаж буй их дээд сургуулийн хөтөлбөрт нийгмийн хөгжил, жендэрийн тухай ойлголт, байгаль орчинд гарч буй өөрчлөлт, байгалийн нөөцийг ашиглах үйл ажиллагааны нийгмийн үр нөлөөг тооцох, судлах агуулгыг оруулах;
- Байгаль орчны салбарын үйл ажиллагааны нийгмийн, түүний дотор жендэрийн үр нөлөөг үйл ажиллагааны чиглэлүүдээр судлах ажлыг ТББ, орон нутгийн оршин суугчдын оролцоотой хийх.

Стратегийн зорилго 2. Байгаль орчны салбарын менежментийг жендэрийн мэдрэмжтэй болгох

Энэхүү зорилго нь жендэрийн стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг туршин хэрэгжүүлж, салбарын бодлогыг жендэрийн мэдрэмжтэй болгоход, түүний дотор хүний нөөцийг жендэрийн мэдрэмжтэй хөгжүүлэхэд чиглэгдэнэ.

Зорилт 2.1. Байгаль орчны салбарын эрх зүйн орчин, бодлого төлөвлөлтийг жендэрийн мэдрэмжтэй болгох

Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл:

- Байгаль орчны салбарын үйл ажиллагаанд хийсэн жендэрийн үнэлгээ, шинжилгээг бодлого төлөвлөлтөд ашиглах эрх зүйн зохицуулалт хийх;
- Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад жендэрийн мэргэжилтний орон тоо бий болгон ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээг батлах;
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн “Хөдөлмөрийн харилцаан дахь эрх тэгш байдлын баталгаа” 11-р зүйлийг байгаль орчны салбарын хүрээнд хэрэгжүүлэх зохицуулалтуудыг хийж төрийн захиргааны төв байгууллага болон салбарын бусад байгууллагуудын дотоод журамд тусгах;
- Байгаль орчны салбарын үйл ажиллагаанд жендэрийн аудитын арга зүйг нэвтрүүлэх;
- Байгаль орчны салбарын санхүүжилт, хөрөнгө оруулалтын үр ашгийн үнэлгээнд жендэрийн төсвийн үзүүлэлт оруулах;
- Байгаль орчны салбарын жендэрийн төлөв байдлын илтгэлийг жил бүр гарган үр дүнг нь салбарын хэмжээнд танилцуулж, Засгийн газарт тайлагнах;
- Ногоон хөгжлийн бодлогод иргэд, эмэгтэйчүүдийн болон жендэрийн асуудлаар ажилладаг ТББ-ууд илүү өргөн хүрээтэй оролцох эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- Байгалийн нөөцийн хамтын менежмент, ой, усны нөөцийн ашиглалттай холбоотой эрх зүйн баримт бичгүүдийг жендэрийн мэдрэмжтэй болгох;
- Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай хамтран байгаль орчны салбарын

хүний нөөцийн хэрэгцээг мэргэжлийн индекс, сургалтын хөтөлбөрүүдтэй уялдуулж, төгсөх ангийн охид хөвгүүдэд сурталчлах ажлыг зохион байгуулах.

Зорилт 2.2. Байгаль орчны салбарын бодлого төлөвлөлтөд бүх шатны хэрэгжүүлэгчдийн, түүний дотор эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх

Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл:

- Байгаль орчны ой, ус, цаг уур зэрэг бүх салбаруудад ажиллагчдын хүний нөөцийн хөгжлийн жендэрийн мэдрэмжтэй урт хугацааны хөтөлбөр гаргаж үйл ажиллагааны чиглэл тус бүрт хэрэгжүүлэх;
- Бодлого боловсруулах, төлөвлөхөд (жишээ нь хүний нөөцийн сургалтын төлөвлөгөө) тухайн асуудал хариуцсан бүх шатны байгууллагад ажиллагчдын саналыг авах жендэрийн мэдрэмжтэй механизм бий болгох;
- Байгаль орчны чиглэлийн хороо, зөвлөлүүдэд ажиллагчдын дотор аль нэг хүйсийн төлөөллийн эзлэх хувийг хамгийн багадаа 30 хувь хүргэх боломжийг судлан зохицуулалт хийж, нөлөөллийн ажил зохион байгуулах;
- Жендэрийн чиглэлээр мэргэшин суралцсан байгаль орчны чиглэлийн мэргэжилтнүүдийн судалгаа явуулж мэдээллийн сан үүсгэн, тэдний мэдлэг туршлагыг бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд үр дүнтэй ашиглах боломжийг бүрдүүлэх.

Зорилт 2.3. Байгаль орчны бодлого төлөвлөлт болон орон нутгийн хөгжлийн бодлогын жендэрийн уялдааг сайжруулах

Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл:

- Орон нутгийн хөгжлийн чиг хандлага болон байгалийн нөөц, байгаль орчны хүчин зүйлүүдийн уялдааг жендэрийн мэдрэмжтэй шинжлэх ажлыг сонгосон 5 аймаг, 2 дүүрэгт олон талын оролцоотой зохион байгуулах;
- Ногоон хөгжлийн бодлого, ой, ус, цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрүүдийг орон нутгийн, эмэгтэй эрэгтэй хүмүүсийн, хүн амын бүлгүүдийн хөгжлийн хэрэгцээнд суурилан хэрэгжүүлэх гарын авлагыг хот, хөдөөд зориулан боловсруулж орон нутгийн шийдвэр гаргагчдад түгээн ашиглуулах;
- Байгаль орчны бодлого төлөвлөлтийг орон нутгийн хөгжлийн бодлогод жендэрийн мэдрэмжтэйгээр нэгтгэх аргачлал боловсруулан түгээх.

Стратегийн зорилго 3. Эмэгтэй эрэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүд, орон нутгуудад ногоон хөгжилд оролцох, үр ашгийг нь хүртэх илүү өргөн боломжийг нээх

Энэ зорилго нь ногоон хөгжлийн үйл ажиллагааг дэмжин оролцох өргөн хүрээний түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлж, хүмүүсийн тулгамдсан хэрэгцээг байгаль орчинд илүү ээлтэй арга замаар шийдэх хандлага, мэдлэг ойлгоцыг төлөвшүүлэх, түгээн дэлгэрүүлэх суурь болно.

Зорилт 3.1. Байгаль орчны салбарын мэдээллийг илүү хүртээмжтэй болгох, эмэгтэй эрэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүд, орон нутгуудын оролцооны чадавхийг дээшлүүлэх

Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл:

- Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, гамшгаас сэргийлэх чиглэлээр эмэгтэй эрэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүдэд зориулан гаргаж буй мэдээлэл, зааварчилгааг эмэгтэй эрэгтэй хүмүүсийн жендэрийн үүрэг, хэрэгцээнд тохируулах, түгээх ажлыг орон нутгийн бүлгүүдийн оролцоотой хийх;
- Байгаль орчны чиглэлээр ажиллаж буй ТББ-уудын үйл ажиллагааны чиглэлийг өргөжүүлэн, ногоон хөгжлийн хөтөлбөртэй уялдуулахад чиглэсэн сургалт, нөлөөллийн ажил хийх;
- Сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөнд олон нийтийн санал зөвлөмж авах, хэрэгжилтийг хянан олон нийтэд тайлагнах ажилд жендэрийн тэгш оролцоог хангах;
- Ойн нөхөрлөлийн гишүүдийн мэргэжин суралцах чиглэлийг жендэрийн мэдрэмжтэй судлан тодорхойлох;
- Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг барих стандарт шаардлагыг ойлгомжтой хэлбэрээр иргэдэд сурталчлан таниулах ажлыг орон нутгийн бүлгүүд, ИНБ-ын оролцоотой зохион байгуулах;
- Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулиудын хичээлүүдийн хөтөлбөр дэх экологийн боловсрол олгох мэдээллийг жендэрийн мэдрэмжтэй болгон, эмэгтэй эрэгтэй хүмүүсийн байгаль орчноо хамгаалж ирсэн ардын уламжлалаар баяжуулах.

Зорилт 3.2. Орон нутгийн иргэд, бүлэг нөхөрлөлүүд, эрдэм шинжилгээний байгууллагууд, ИНБ болон олон улсын байгууллагуудыг байгаль орчны салбарын бодлого төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээнд илүү үр дүнтэй оролцуулах

Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл:

- Салбарын жендэрийн стратегийг олон улсын байгууллагуудад сурталчлан танилцуулж, дэмжих чиглэлийг зөвшилцөх уулзалтыг стратегийн хэрэгжилтийн үе шат бүрт зохион байгуулах;
- Хот тохижилт, ногоон байгууламжийн тухай хуулийг мэргэжилтнүүд болон олон нийтийн оролцоотой жендэрийн мэдрэмжтэйгээр боловсруулан батлуулах;
- Хот суурин газрын ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэх зураг төслийг гаргаж, орон нутгийн төсөвт тусгуулах, хэрэгжүүлэх ажилд орон нутгийн эмэгтэй эрэгтэй хүмүүс, аж ахуйн нэгжүүд, ИНБ-ийн оролцоог нэмэгдүүлэх;
- Сав газрын зөвлөлд эмэгтэй эрэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүдийн төлөөллийн оролцоог ханган, байгалийн нөөцийн ашиглалтын талаар шийдвэр гаргахад оролцуулах механизмыг бий болгох;
- Усны сав газрын зөвлөлийн хийх усны тогтвортой менежментийг хангахад чиглэсэн нийгэм эдийн засгийн судалгааг жендэрийн мэдрэмжтэй болгох;
- Байгалийн нөөцийн ашиглалт, үйлдвэрлэлийн хуримтлагдсан нөлөөлөл, байгаль орчинд учруулсан хохирлын үнэлгээнд жендэрийн мэдрэмжтэй үзүүлэлт оруулж иргэд, ТББ-ын оролцоог хангах;
- Гэр хорооллын нүхэн жорлон, хөрсний бохирдлоос хамгаалах болон усны чанар, ундны усны хангамжийн асуудлыг хариуцсан байгууллагуудын хариуцлага, уялдаа холбоог орон нутгийн иргэдтэй хамтарсан тогтмол уулзалт хэлэлцүүлгүүдээр дамжуулан сайжруулах;
- Байгаль орчинд ээлтэй, хүний амьдрах орчны аюулгүй байдлын шаардлага хангасан хот суурин газрын загварыг нийгмийн бүлгүүдийн оролцоотой гаргаж хэрэгжүүлэх.

Зорилт 3.3. Эмэгтэй эрэгтэй хүмүүсийн, нийгмийн бүлгүүдийн, орон нутгуудын хэрэгцээнд нийцсэн ногоон ажлын байрыг нэмэгдүүлэх

Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл:

- Хотын хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр орон нутгийн иргэд, ТББ-уудыг өргөн оролцуулсан хэлэлцүүлэг хийж хог ангилах, ялгах гэх мэт чиглэлээр ногоон ажлын байр бий болгох боломжийг судлан хэрэгжүүлэх;
- Уул уурхай хөгжиж байгаа орон нутгуудад нөхөн сэргээлт, газар тариалан, хүнсний үйлдвэрлэл, эко аялал жуулчлал зэрэг чиглэлээр эмэгтэйчүүдэд зориулсан ногоон ажлын байр бий болгох;
- Ойн модны үйлдвэрлэлийн шинэ техник, технологи эзэмших, хос мэргэжил эзэмшин байнгын ажил эрхлэх боломжийг эмэгтэй эрэгтэй хүмүүст тэгш бүрдүүлэх арга замыг судлах;
- Малчин, тариаланч өрхийн, орон нутгийн бүлгүүдийн хэрэгцээнд нийцсэн, түүхий эдэд нь түшиглэсэн, байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи нэвтрүүлэх ажлыг жендэрийн мэдрэмжтэй болгох.

ГУРАВ. ЖЕНДЭРИЙН СТРАТЕГИЙН ХЭРЭГЖИЛТ

3.1 Стратегийг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалт

Байгаль орчны салбарын жендэрийн стратегийг БОНХЯ удирдан зохион байгуулна. Стратегийн хэрэгжилтийг БОНХЯ-ны дэргэдэх Жендэрийн салбар зөвлөл хариуцан гүйцэтгэнэ.

Байгаль орчны асуудлаарх салбар дундын бодлого хөтөлбөр, үйл ажиллагааг зохицуулах ерөнхий чиг үүрэгтэй БОНХЯ нь бусад салбарын болон чиг үүргийн яамдын, орон нутгийн байгууллагуудын ногоон хөгжлийн үйл ажиллагааг жендэрийн мэдрэмжтэй хэрэгжүүлэхэд үлгэр жишээ болж, уялдуулан зохион байгуулна.

БОНХЯ-ны Жендэрийн салбар зөвлөл нь энэ стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг салбарын хэмжээнд уялдуулан зохицуулах, арга зүйн дэмжлэгээр хангах, салбарын төлөвлөлт болон төсөвт тусгах, стратегийн үзэл санааг, гадаад, дотоодын хөрөнгө оруулагч сонирхогч талууд, дэмжигч нарт сурталчлан таниулах, хөрөнгө санхүүжилт босгох асуудлыг хариуцна.

Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газар нь жендэрийн стратегийн үзэл санааг ногоон хөгжлийн бодлого төлөвлөлтөд тусгах, олон улсын болон бүс нутгийн түвшинд дэвшүүлж буй шинэ санаачлага, хөтөлбөрүүдтэй холбон уялдуулах ажлыг зохион байгуулна.

Төрийн захиргаа, удирдлагын газар нь салбарын хүний нөөцийн бодлогыг жендэрийн мэдрэмжтэй төлөвлөх, эрэгтэй, эмэгтэй албан хаагчдын ажлын бүтээмжийг дээшлүүлэх боломжтой ажиллах орчинг бүрдүүлэх үүргийг хүлээнэ.

Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газар нь байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх ажилд олон нийтийн оролцоог хангах, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлнэ.

Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар нь ой, ус, цөлжилт гэх мэт байгаль орчны асуудлаар төрөөс баримталж буй бодлогыг жендэрийн мэдрэмжтэй төлөвлөх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлагын газар нь тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний хамтын менежментийг жендэрийн мэдрэмжтэй болгох ажлыг хариуцна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь жендэрийн стратегийн хэрэгжилтийн явцад хяналт тавьж, үнэлгээ өгнө. Жендэрийн аудитын арга зүйг боловсруулах, байгаль орчны салбарын хэмжээнд жендэрийн аудитыг нэвтрүүлэх ажлыг хийж, жендэрийн статистик мэдээллийн санг байгаль орчны салбарын статистик мэдээллийн сантай уялдуулах, нээлттэй байдлыг хангах, судалгаа, жендэрийн дүн шинжилгээний үр дүнг бодлого боловсруулахад ашиглах ажлыг зохион байгуулна.

Хэвлэл мэдээллийн алба нь байгаль орчны салбарын жендэрийн стратегийг хэрэгжүүлэх үйл явц, үр дүнг олон нийт, оролцогч талуудад сурталчлах ажлыг зохион байгуулна.

Жендэрийн стратеги нь байгаль орчны салбарын аль нэг чиглэлийн үйл ажиллагаагаар үл хязгаарлагдахын зэрэгцээ хэрэгжилтийн 2-р үе шат буюу 2017-2020 онуудад сонгосон 5 аймаг, 2 дүүрэг нь өөрсдийн нөхцөл байдал, хэрэгцээнд тохируулан туршиж болохуйц уян хатан зохицуулалтаар хангана.

Жендэрийн стратегийн тогтвортой хэрэгжилтэд өнөөгийн дөрвөн жилийн сэлгээтэй улс төр, засаглалын тогтолцоо болон төсвийн санхүүжилт нь гол эрсдэл үүсгэх магадлалтай учраас шинээр томилогдсон засгийн газар болон орон нутгийн удирдлагуудад тус стратегийг танилцуулах ажлыг засаглалынхаа эхний жилд зохион байгуулж, шаардагдах санхүүжилтийг төсөвт тусгаж байх шаардлагатай. Мөн уг стратегийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын, ялангуяа олон улсын болон иргэний нийгмийн байгууллагууд, жендэрийн мэргэжсэн байгууллагуудын түншлэл хамтын ажиллагааг хөгжүүлэх нь засаглалын үйл ажиллагааны залгамж халааг сайжруулах, байгаль орчны чиглэлийн төр, бизнес, иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо хангалтгүй байгаагаас үүдэн гарах бусад эрсдлийг даван туулахад амин чухал.

Байгаль орчны салбарын жендэрийн стратегийг 2030 он хүртэл гурван үе шатаар хэрэгжүүлнэ.

I үе шат: 2014-2016

Энэ үе шатанд байгаль орчны салбарын бодлого боловсруулагчид жендэрийн мэдлэг, арга зүй эзэмшин жендэрийн бодлого, төлөвлөлт хийх институцийн дотоод чадавхи бүрдэж, жендэрийн хяналтын хуудас боловсруулагдан хэрэглэгдэж эхэлнэ.

Стратегийн эхний үе шат нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх Засгийн газрын дунд хугацааны стратегийн үр дүнтэй уялдана.

II үе шат: 2017-2020

Энэ үе шатанд байгаль орчны салбарын үйлчилгээ жендэрийн мэдрэмжтэй болж, орон нутагт жендэрийн бодлогыг хэрэгжүүлэх чадавхи бүрдэнэ. Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлогыг жендэрийн мэдрэмжтэй болгох туршилтын төслийг **Архангай, Булган, Өвөрхангай, Ховд, Хэнтий аймаг**, Нийслэлийн Сонгинохайрхан, Сүхбаатар дүүрэг хэрэгжүүлж, байгаль орчны салбарын бүх чиглэлийн үйл ажиллагаанд жендэрийн үр нөлөөний үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтүүд боловсруулагдан туршилтын аймаг, дүүргүүдэд хэрэглэгдэж, орон нутгийн хөгжлийн бодлогыг байгаль орчны жендэрийн мэдрэмжтэй бодлоготой уялдахад чиглэгдсэн

зохицуулалтууд хийгдэнэ. Жендэрийн хяналтын хуудас салбарын үйл ажиллагааны бүх чиглэлд ашиглагдана.

Хоёрдугаар үе шат нь Ногоон хөгжлийн үзэл баримтлал, Ногоон хөгжлийн дунд хугацааны хөтөлбөртэй уялдана.

III үе шат: 2021-2030

Энэ үе шатанд байгаль орчны салбарын бодлого төлөвлөлт, хэрэгжилт жендэрийн бүрэн мэдрэмжтэй болж, салбар хоорондын жендэрийн бодлого, хэрэгжилтийн зохицуулалтын механизм бүрдэнэ. Байгаль орчны салбарт жендэрийн аудитын тогтолцоо бий болж, байгаль орчны салбарын жендэрийн стратегийн туршлага бусад салбаруудад түгэн дэлгэрч, сонгосон 5 аймаг, нийслэлийн 2 дүүрэгт хийгдсэн туршилтын үйл ажиллагааг үндэсний хэмжээнд түгээн хэрэгжүүлнэ.

Гуравдугаар үе шат нь Ногоон хөгжлийн үзэл баримтлал, тогтвортой хөгжлийн үзүүлэлтүүдтэй уялдана.

3.2. Стратегийн санхүүжилт

Байгаль орчны салбарын жендэрийн стратегийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө санхүүгийн нөөцийг стратегийг хэрэгжүүлэх үе шатуудтай уялдуулан төлөвлөнө.

Стратегийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг дараах эх үүсвэрүүдээс хангана. Үүнд:

- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө
- Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, хандивлагчдын тусламж, төсөл хөтөлбөр.

Байгаль орчны салбарт дэмжлэг үзүүлдэг гадаад, дотоодын хандивлагч байгууллагуудын хэмжээнд БОНХЯ-ны жендэрийн салбар зөвлөлөөс жил бүр уулзалт зохион байгуулж, БОНХЯ болон салбарын хэмжээнд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, дэмжлэгийнхээ хамгийн багадаа гурван хувийг жендэрийн стратегийн үйл ажиллагаанд зарцуулах талаар зөвшилцөж баталгаажуулна.

3.3 Стратегийн хэрэгжилтийн хяналт үнэлгээ, тайлагналт

Хяналт үнэлгээний зорилго нь үйл ажиллагааны хэрэгжилтийг хангуулах, үр дүнд хүрэх явцад гарсан ололт амжилт, ахиц дэвшилт, хүндэл бэрхшээл, алдаа дутагдалтай асуудлуудыг тодорхойлох, тодорхой нөхцөл байдалтай уялдуулан стратегийн төлөвлөгөөнд зохицуулалт хийх талаар санал, дүгнэлт гаргахад чиглэгдэнэ.

Байгаль орчны салбарын жендэрийн стратегид тодорхойлсон зорилгын хэрэгжилтийн явцад үнэлгээ хийж, үр дүнг үнэлэх үе шатууд:

Нэгдүгээр үе шат:	Стратегийн хэрэгжилтийн эхний үе шатны хяналт, үнэлгээ (Хугацаа 2017 оны 1 сар)
Хоёрдугаар үе шат:	Дунд хугацааны хяналт, үнэлгээ (Хугацаа 2021 оны 1 сар)
Гуравдугаар үе шат:	Төгсгөлийн хяналт, үнэлгээ

(Хугацаа 2030 оны 12 сар)

БОНХЯ-ны жендэрийн салбар зөвлөл нь стратегид төлөвлөсөн үйл ажиллагааны явц, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүдийг үнэлж, жил бүрийн тайландаа тусгана. Байгаль орчны салбарын жендэрийн стратегийн үр дүнг үнэлэх үндсэн шалгуур үзүүлэлтүүд нь байгаль орчны статистик мэдээлэл, байгаль орчны үзүүлэлтүүдийн нэг хэсэг байх ба энэ стратегийг хэрэгжүүлэх удирдлагын бүрэлдэхүүн хэсэг болно.

Стратегийн үе шат тус бүрт “Байгаль орчны салбарын жендэрийн үнэлгээ” хийнэ. Тус үнэлгээг БОНХЯ-ны жендэрийн салбар зөвлөл нь өөрийн гишүүдээс эсвэл бие даасан жендэрийн зөвлөхүүдээр хийлгэж болно. “Байгаль орчны салбарын жендэрийн үнэлгээ”- хийхэд стратегийг үнэлэх үндсэн шалгуур үзүүлэлтүүдээс (Хавсралт 2.) гадна нийгмийн үр нөлөө, эрэгтэй эмэгтэй хүмүүсийн амьдралын чанарыг үнэлэхэд олон улсын түвшинд хэрэглэж байгаа шалгуур үзүүлэлтүүд болон эрүүл мэндийн шалгуур үзүүлэлтүүдийг нэмэлт болгон хэрэглэх шаардлагатай. Жишээлбэл дараах нэмэлт үзүүлэлтүүд ашиглаж болно. Үүнд:

- Баталгаатай ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувь, жилээр
- Хот суурин газрын нэг хүнд ноогдох усны хангамж (литр/хоног/нэг хүн), жилээр
- Хөдөөгийн нэг хүнд ноогдох ундны болон эрүүл ахуйн хэрэгцээний усны хэрэглээ (литр/хоног/нэг хүн)
- Байгаль орчны салбарын мэдээллийг үйл ажиллагаандаа ашиглаж, амжилттай хэрэгжүүлсэн бүлгүүдийн дундаж тоо, бүсээр, аймгаар

Олон нийт болон хамтрагч нарт стратегийн хэрэгжилтийг тайлагнах, мэдээлэх ажлыг БОНХЯ-ны хэвлэл мэдээллийн алба зохион байгуулна.

Стратегийн хэрэгжилтийн явц, үр дүн, цаашид авах арга хэмжээг яамны түвшинд газар, хэлтсийн дарга нар, аймаг, нийслэлийн түвшинд байгаль орчны асуудал хариуцсан газрын дарга нар яамны жендэрийн салбар зөвлөлд болон орон нутгийн удирдлагуудад жил бүрийн эцэст мэдээлж, тайлагнаж байна.

3.4. Хамтын ажиллагаа

Байгаль орчны салбарын жендэрийн стратегид тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэхэд БОНХЯ-ны жендэрийн салбар зөвлөл, байгаль орчны салбарын байгууллагууд, холбогдох яамд, агентлагууд, аймаг, нийслэлийн засаг захиргаад, төрийн бус болон хувийн хэвшил, олон улсын байгууллагууд хууль тогтоомжийн хүрээнд оролцож, хамтран ажиллах нь нээлттэй байна.

УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо байгаль орчны асуудлаарх эрх зүйн орчинг сайжруулах, шинээр батлах хууль, тогтоомжийг жендэрийн стратегийн үзэл баримтлал, хандлагатай уялдуулна.

Жендэрийн үндэсний хороо үндэсний хэмжээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудлыг зохицуулдаг үүргийнхээ хүрээнд байгаль орчны салбарын жендэрийн стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн, салбар хоорондын жендэрийн асуудлыг уялдуулан, сайн туршлагыг түгээж ажиллана.

Аймаг, нийслэлийн засаг захиргаа орон нутгийн хөгжлийн бодлогоо байгаль орчны бодлого хөтөлбөртэй уялдуулахдаа жендэрийн стратегийн үзэл санааг тусгах ажлыг хариуцан зохион байгуулна.

Боловсрол шинжлэх ухааны яам байгаль орчны асуудлаарх иргэдийн боловсролыг дээшлүүлэх, боловсон хүчнийг бэлтгэх хөтөлбөрүүдийг боловсруулж батлахдаа жендэрийн стратегийн зорилтуудыг анхааран үзнэ.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр 2016 он хүртэлх Монгол улсын засгийн газартай хамтран хэрэгжүүлэх хөтөлбөртөө тусламжийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг байгалийн нөөцийн менежментийн тогтвортой байдал, уур амьсгалын өөрчлөлтөд экосистем ба хүн амын эмзэг бүлгийнхний дасан зохицох чадавхийг сайжуулахдаа жендэрийн дүн шинжилгээнд суурилан байгаль орчны бодлого, стратегид жендэрийн тэгш байдлыг тусгана гэж заасан. Энэ хүрээнд НҮБХХ-тэй стратегийн 2-р зорилгыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллана.

Швейцарийн Хөгжлийн агентлаг 2016 он хүртэлх Монгол улсад хэрэгжүүлэх хамтын ажиллагааны стратегид жендэрийн тэгш байдалд гарсан ололт, амжилт, ахиц дэвшлийг онцолно гэж заасан бөгөөд хөгжлийн туслалцаа, дэмжлэг үзүүлэх нэг үндсэн чиглэлээ жендэрийн асуудал гэж үзсэн нь байгаль орчны салбарын жендэрийн стратегийн зорилтыг, ялангуяа 3-р зорилгыг хэрэгжүүлэх хамтын ажиллагааны суурь болно.

Германы хамтын ажиллагаа нь БОНХЯ-тай хамтран хэрэгжүүлж буй “Биологийн олон янз байдал ба уур амьсгалын өөрчлөлтөнд ойн гол экосистемүүдийн дасан зохицох нь” хөтөлбөрийн хүрээндээ байгаль орчны салбарын жендэрийн асуудлыг тусгасан нь стратегийг хэрэгжүүлэх, үр нөлөөг үнэлэх судалгааны ажилд техникийн дэмжлэг үзүүлэх нөхцлийг бүрдүүлж байна.

Эрдэм шинжилгээний байгууллагууд стратегийн жендэрийн судалгаа шинжилгээний ажлыг хийхэд мэргэжил арга зүйн дэмжлэгээр хангана.

Иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл, төрийн бус байгууллагууд нь ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтэд орон нутгийн, олон нийтийн тэгш оролцоог нэмэгдүүлэх, салбарын бодлого төлөвлөлт, үйл ажиллагааны жендэрийн үр нөлөөг үнэлэх, бодлогод тусгах чиглэлээр нөлөөллийн ажил хийхэд идэвхтэй оролцоно.